



**ЦУС СЭЛБЭЛТ СУДААЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2022 оны 11 сарын 29 өдөр

Дугаар A/81

Улаанбаатар хот

Цахим семинар зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/506, 2020 оны А/445 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цусны салбар төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд цахим семинар зохион байгуулах ажлын удирдамжийг 1 дүгээр, төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Цахим семинарыг 2022 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн дотор зохион байгуулж, дүнг танилцуулахыг Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /А.Амарзаяа/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн албаны дарга /Б.Солонго/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны // сарын 29 өдрийн
.....А/8/..... дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

1118266548 9126905

ЦАХИМ СЕМИНАР ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Цусны албаны үйл ажиллагааг аюулгүй явагдах, нөхцлийг бүрдүүлж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахад энэ ажлын гол зорилго оршино.

Хоёр. Зорилт:

- Эмч, мэргэжилтнүүд харилцан туршлага солилцох сайн соёлыг хэвшүүлэх
- Тусламж үйлчилгээтэй холбоотой эрсдлийн үнэлгээ хийх арга зүйд сургах
- ЦСТ-үүдийн цахим программ ашиглалтыг нэмэгдүүлэх, тайлагналтыг боловсронгуй болгох

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Эмч, мэргэжилтнүүдэд эрсдлийн үнэлгээ хийх сургалт зохион байгуулна.
2. Цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээтэй холбоотой сайн туршлагыг дэлгэрүүлэх
3. Цахим программ ашиглахад тулгардаг нийтлэг асуултад хариулт өгөх

Дөрөв. Хугацаа

2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр

Тав. Хамрах хүрээ


Цусны 26 салбар төвүүд

Зургаа.Хариуцах эзэн

Цусны чанар, аюулгүй байдлын алба, Эрдэм шинжилгээ, мэдээлэл технологийн алба, Захиргаа маркетингийн албаны холбогдох мэргэжилтнүүд

---oOo---

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2022 оны 11 сарын 29 өдрийн
... дугаар тушаалын
2 дугаар хавсралт



ЦАХИМ СЕМИНАРЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан хаагч
1.	Нээлт	20 минут	Н.Эрдэнэбаяр
2	Эрүүл мэндийн байгууллагын эрсдлийг үнэлэх аргачлал	30 минут	А.Амарзаяа
3	“Сайн туршлага” - Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн “Цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээ” -ний талаар анхаарах асуудал	40 минут	Орхон аймгийн Нэгдсэн эмнэлгийн ЦСТ-ийн эрхлэгч эмч
4	Үндсэн үйл ажиллагааны мэдээ тайлан ирүүлэхэд анхаарах асуудлууд	30 минут	Эдийн засагч, статистикч Н.Соёлмөнх
5	Цахим програмын ашиглалтыг сайжруулах талаар зөвлөгөө	20 минут	Ч.Далайцэрэн

---oOo---